

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Агуулга**

1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	12
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн, өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Т.БОЛДБААТАР ТАНАА

2020.03.13 № 06/807  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


Ажиллагсдад ажлын үр дүнг тооцож дүгнэлгүй 226.5 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон нь үнэн зөв, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал Т.Болдбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн НБББББ-д тусгагдсан биет бус хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 1/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол улсын хамгийн том Усан цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартын дагуу бүтээн байгуулахад оршино.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эгийн голын усан цахилгаан станцын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоол
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол;

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Эн Эм Эм Эй” ХХК-ийн Эрхэт программ хангамж ашиглаж байна.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,718.6 сая төгрөгөөс тооцон 57.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшин 47.3 сая төгрөг болж өөрчлөгдсөн болно.

**2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 679.5 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	588.5	0.3	(588.2)
Авлага	1.0	0.8	(0.2)
Урьдчилгаа	11,246.3	11,229.5	(16.8)
Бараа материал	17.6	10.5	(7.1)
Үндсэн хөрөнгө	18,926.0	18,858.8	(67.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>30,779.4</b>	<b>30,099.9</b>	<b>(679.5)</b>
Өр төлбөр	31,406.8	35,449.4	4,042.6
Эздийн өмч	(627.4)	(5,349.5)	(4,722.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>30,779.4</b>	<b>30,099.9</b>	<b>(679.5)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь харилцах дансны үлдэгдлээс 2019 оны 9 дүгээр сар хүртэл цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар болон бусад урсгал зардлыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 11,229.5 сая төгрөг байна. Энэ нь Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ-ийг боловсруулахтай холбогдож гарсан судалгааны ажлын зардлыг хуримтлуулж бүртгэсэн байна.

Одоогийн байдлаар уг ТЭЗҮ нь Хөгжлийн банкны урт хугацаат зээлийн барьцаанд байгаа болно.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл нь “Ви-вит технологи” ХХК-с программ хангамжийн урьдчилгаанд төлсөн 15.0 сая төгрөгийг буцааж авсан мөн урьдчилж төлсөн шатахууны зардал 1.5 сая төгрөг, урьдчилж төлсөн даатгалын зардал 0.3 сая төгрөг, нийт 16.8 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 7.1 сая төгрөгөөр буурсан нь албан хэрэгцээнд зарцуулсан бичиг хэрэг, сэлбэг, хангамжийн материалын зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл элэгдлийн зардлаар буурсан байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл нийт 4,042.6 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 237.4 сая төгрөг байгаа нь 2016-2018 онд үүссэн Тул хамгаалах сан 85.1 сая, Баясал төгс ХХК-д төлөх 7.6 сая нийт 92.7 сая төгрөг нь судалгааны ажлын үлдэгдэл төлбөр болно. Тайлант онд санхүүжилтийн эх үүсвэргүй болсонтой холбоотой цалингийн өглөг 85.5 сая, ХХОАТ-ын өглөг 10.5 сая, НДШ-ийн өглөг 19.5 сая, Камдер ХХК-д түрээсийн төлбөр 28.1 сая, харилцаа холбоо, газрын төлбөр 1.1 сая нийт 144.7 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Нийт урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 35,212.1 сая төгрөг байна. Энэ нь Монгол улсын хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн үндсэн төлбөр 28,972.6 сая төгрөг, хүүгийн төлбөр 6,239.5 сая төгрөг байна. Уг зээлийг Эгийн голын усан цахилгаан станцын төсөл санхүүжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн байна.

## 2.9. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн 76 тоот тушаалаар Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2

019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна.

Тайлант онд 6.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,803.6 сая төгрөг зарцуулж 6,797.6 сая төгрөгийн алдагдалтай зорилтот түвшнийг баталсан байна. Зарцуулалтын эх үүсвэрийг Хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

Урсгал зардалд 1,145.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардал 10.1 сая төгрөг, үндсэн зээлд тооцсон ханшийн зөрүү болон хүүгийн зардалд 5,487.0 сая, бусад зардал 161.0 сая нийт 6,803.6 сая төгрөгийн зардал батлагдсанаас 4,725.9 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй байна.

Алдагдлыг 6,797.6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,722.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,218.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 992.2 сая төгрөгийн алдааг залруулж, 226.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

- Биет бус хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолоход газар эзэмших эрхийн бүртгэлд элэгдэл байгуулж санхүүгийн тайланд 992.3 сая төгрөгийг тусгасан нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлалын 5.5-д заасан “Газар эзэмших болон ашиглах эрхтэй бол биет бус хөрөнгөөр бүртгэх бөгөөд цаашид элэгдүүлэхгүй” гэсэн заалттай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг залруулав.

- Цалингийн нэмэгдлийг 100 хувиар тооцон хавтгайруулан 226.5 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 7 дугаар 10-ны өдрийн Засгийн газрын гадаад хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 6 дугаар хавсралт Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын хөлсний жишигтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эгийн голын усан цахилгаан станцын төсөл БНХАУ-ын Засгийн газрын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр баригдаж эхэлсэн бөгөөд Дэлхийн өвд бүртгэгдсэн Байгал нуурт нөлөөлөх тухай асуудлыг Оросын талаас Хятадын талд албан ёсоор хандсанаар төслийн ажил зогсонги байдалд хүрсэн. Сэлэнгэ мөрний урсацын судалгааг Трактебл инжнеринг ХХК-иар хийлгэж Байгаль нуурт нөлөөгүй гэсэн дүгнэлт гарсан боловч



ОХУ-аас Сэлэнгэ мөрний амьтан ургамалд нөлөөлнө гэж үзсэн учир Францын ВРЛ инженер ХХК, Монголын Санни трейд ХХК болон Престиж инженеринг ХХК-ийн түншлэлээр биологийн олон янз байдлын судалгааны ажил хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, 2019 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 394 дүгээр тогтоолоор Эгийн голын усан цахилгаан станцын төслийг цаашид үргэлжлүүлэх талаар Сангийн яам болон Эрчим хүчний яаманд чиглэл өгсөн байна.

Одоогоор тус байгууллага нь Хөгжлийн банкнаас зээлээ үргэлжлүүлж авахаар материалаа хүргүүлсэн бөгөөд дэмжигдэж байгаа.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 59 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, 101.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 25.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 226.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 47.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагад одоо мөрдөгдөж байгаа НБББББ-д тусгасан биет бус хөрөнгийн бүртгэл нь стандарт, аргачлалд нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон шинэчлэгдсэн стандартын дагуу НБББББ-ийг шинэчлэн боловсруулах

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	588,492,800.76	298,367.74
1.1.2	Дансны авлага	850,000.00	850,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	118,023.72	
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	17,659,116.50	10,522,138.78
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,246,318,417.79	11,229,492,123.79
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,853,438,358.77</b>	<b>11,241,162,630.31</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	284,897,512.11	219,640,031.99
1.2.2	Биет бус хөрөнгө	18,641,098,241.82	18,639,153,956.82
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>18,925,995,753.93</b>	<b>18,858,793,988.81</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,779,434,112.70</b>	<b>30,099,956,619.12</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	92,718,000.00	92,718,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		85,466,900.29
2.1.1.3	Татварын өр	341,023.60	10,473,507.12
2.1.1.4	НДШ–ийн өглөг		19,437,754.14
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		29,293,246.42
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>93,059,023.60</b>	<b>237,389,407.97</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	28,012,345,077.91	28,972,615,710.45
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,301,470,630.47	6,239,476,004.22
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>31,313,815,708.38</b>	<b>35,212,091,714.67</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>31,406,874,731.98</b>	<b>35,449,481,122.64</b>

<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	20,000.00	20,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,635,520,000.00	18,635,520,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-12,788,627,416.55	-19,262,980,619.28
2.3.10	Тайлант үеийн ашиг	-6,474,353,202.73	-4,722,083,884.24
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>-627,440,619.28</b>	<b>-5,349,524,503.52</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>30,779,434,112.70</b>	<b>30,099,956,619.12</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	-	-
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	7,462,497.28	4,109,995.37
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	-	150,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	39,387,045.20	974,200.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,384,765,063.49	806,067,504.65
11	Санхүүгийн зардал	2,438,484,587.30	2,762,157,631.91
12	Бусад зардал	59,364,587.47	20,636,498.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,494,032,318.73)	(1,136,082,044.74)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(65,035,848.10)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(6,473,606,953.01)</b>	<b>(4,721,657,884.70)</b>
19	Орлогын татварын зардал	746,249.72	425,999.54
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(6,474,353,202.73)</b>	<b>(4,722,083,884.24)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(6,474,353,202.73)</b>	<b>(4,722,083,884.24)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00			(12,788,627,416.55)	(12,788,607,416.55)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(6,474,353,202.73)	(6,474,353,202.73)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт			18,635,520,000.00		18,635,520,000.00
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	-	18,635,520,000.00	(19,262,980,619.28)	(627,440,619.28)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,722,083,884.24)	(4,722,083,884.24)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	-	18,635,520,000.00	(23,985,064,503.52)	(5,349,524,503.52)

**4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р Сарын 31	2019 оны 12-р Сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>15,262,401.00</u>	<u>150,000.00</u>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		150,000.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	15,262,401.00	
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<u>1,485,809,595.68</u>	<u>606,348,994.49</u>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	697,324,967.22	332,737,103.93
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	164,057,224.58	93,982,587.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,270,943.00	4,201,965.38
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	359,788,322.49	77,959,438.08
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	38,804,254.64	27,089,120.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	98,680,102.71	35,711,774.96
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,436,590.00	2,017,612.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	100,447,191.04	32,649,392.55
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-1,470,547,194.68</b>	<b>-606,198,994.49</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>12,234,597.28</u>	<u>19,069,995.37</u>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,772,100.00	14,960,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	7,462,497.28	4,109,995.37
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<u>42,495,325.24</u>	<u>1,100,000.00</u>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	40,617,400.00	1,100,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	1,877,925.24	
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-30,260,727.96</b>	<b>17,969,995.37</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>1,926,712,144.21</u>	<u>0.00</u>

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,926,712,144.21	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,926,712,144.21</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(2,817,005.07)</b>	<b>34,566.10</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>423,087,216.50</b>	<b>-588,194,433.02</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>165,405,584.26</b>	<b>588,492,800.76</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>588,492,800.76</b>	<b>298,367.74</b>



**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020.03.10			САГ-2020/32/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК</b>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
2	Тус байгууллагад одоо мөрдөгдөж байгаа НБББББ нь биет бус хөрөнгө бүртгэлийн стандарт, аргачлалд нийцэхгүй байна.		Зөвлөмж	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал, нягтлан бодогч	Т.Болдбаатар Ж.Отгонбаяр
3	Цалингийн нэмэгдлийг 100 хувиар тооцон хавтгайруулан 226.5 сая төгрөгийг олгосон байна.	226.5	Албан шаардлага	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал, нягтлан бодогч	Т.Болдбаатар Ж.Отгонбаяр
4	Биет бус хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолоход газар эзэмших эрхийн бүртгэлд элэгдэл байгуулж тайлан балансад 992.3 сая төгрөгийг тусгасан.	992.2	Аудитын явцад залруулсан	Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал, нягтлан бодогч	Т.Болдбаатар Ж.Отгонбаяр
	Дүн	1,218.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

202 оны 03 дугаар сарын 13

№ 02/122

Улаанбаатар хот

С.НТ-2020/32/СТА-7041

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасан цаглабарт хугацааны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн нэмэгдлийг үр дүн тооцолгүй 100 хувиар тооцон хавтгайруулан 226.5 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар 10-ны өдрийн Засгийн газрын гадаад хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 6 дугаар хавсралт Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын хөлсний жишигтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1 -д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байхад анхаарах;
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн захирал Т.Болдбаатар, нягтлан бодогч Ж.Отгонбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР Л.МӨНХЦАЦРАЛ  
“БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТОР Д.ХОРОЛСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ

Т.БОЛДБААТАР  
НЯГТЛАН БОДОГЧ  
Ж.ОТГОНБАЯР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



